

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт: **ҮБХИС-ИЙН НОРМЫН ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ
НИЙЛҮҮЛЭХ**

Тендерийн дугаар: **БХЯ/202001022**

Улаанбаатар хот
2020 он

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА
/Харьцуулалтын арга/

2020.05.25

Батлан хамгаалах яам нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ҮБХИС-ИЙН НОРМЫН ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ** нийлүүлэх, **БХЯ/202001022** дугаартай тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Борлуулалтын хэмжээ: Тендерт ирүүлсэн 2019 оны санхүүгийн тайлангийн борлуулалтын орлого нь тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байна. 2019 оны түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байна
2019 оны санхүүгийн тайлан ирүүлнэ.
Санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй хэмжээний ижил төстэй бараа, ажил, үйлчилгээг сүүлийн 2 жилд дор хаяж нэг удаа гүйцэтгэсэн байна;

Үнийн саналыг 2020 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 10:00 цагаас өмнө Батлан хамгаалах яам, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Дандарын гудамж -51, Засгийн газрын 7 дугаар байр (213 тоот, дэд хурандаа Б.Түвшинтөр, Утас:263229)

Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан цахимаар тендерийг 2020 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 10.10-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn/ болон доорх хаягаар авна.

Хаяг: Батлан хамгаалах яам, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Дандарын гудамж -51, Засгийн газрын 7 дугаар байр, 213 тоот, дэд хурандаа Б.Түвшинтөр, Утас:263229

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2019 оны жилийн санхүүгийн тайлан /цахим системээс үнэлгээ хийнэ/ Сүүлийн [2019 оны] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбарыг ирүүлэх/; Хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй талаарх оролцогчийн мэдэгдэл. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Байхгүй</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2020 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 10:00 цагаас өмнө “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д Батлан хамгаалах яамнаас зарласан үнийн санал авах тендерт оролцогч өөрийн тендерийн материалыг оруулсан байна.</p> <p>Байгууллагын хаяг: Батлан хамгаалах яам, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Дандарын гудамж -51, Засгийн газрын 7 дугаар байр, 213 тоот</p> <p>Давхар болон өрөөний дугаар: “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д оролцогч үнийн санал ирүүлэх тендерийн материалыг оруулна. Огноо: 2020 оны 06 дугаар сарын 02-ний өдөр Цаг: 10:00 цаг</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Батлан хамгаалах яам, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Дандарын гудамж -51, Засгийн газрын 7 дугаар байр, 1 дүгээр давхарын шилэн танхим. Огноо: 2020 оны 06 дугаар сарын 02-ний өдөр Цаг: 10:00 цаг 10 мин</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ ирүүлэх 2. Татварын цахим тайлангийн системээс авсан тодорхойлолт /цахим системийн өгөгдлийн дагуу/ 3. Харьяа дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс шимтгэл төлөлтийн өргүйг тодорхойлсон тодорхойлолт ирүүлэх /эх хувь байх/ 4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас өр төлбөргүйг тодорхойлсон тодорхойлолт ирүүлэх /эх хувь байх/ 5. Шүүхийн төрөлжсөн архиваас иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүйг тодорхойлсон тодорхойлолт ирүүлэх /эх хувь байх/ <p><i>Хэрэв шүүхэд аливаа маргаанд хариуцагчаар оролцож байсан бол нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, өр төлбөрийг бүрэн барагдуулсан тухай тодорхойлолт, нотлох баримтыг ирүүлэх.</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц 9: Ажлын өмд цамц, Ажлын гутал, өвлийн хөвөнтэй хүрэм, Бязь даавуун цамц, өмд, малгай, цээживчтэй хормогч, хулдаасан хормогч, бязь даавуун нөмрөг, даавуун халаад, малгай / номын санч/, богино ханцуйтай бязь даавуун цамц, өмд, малгай / талхан цех/, Резинэн бээлий, Авто хуягт танк, инженерийн өмд, цамц, брезинтэн бээлий, үйлчлэгчийн хувцас Багц 10: Угаалгын үйлчилгээ /орны цагаан хэрэглэл, майхан цув/</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАГЦ №9 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Тогоочийн ажлын хувцас

Чанар, стандартын шарадлага	
1	Бяз даавуу хөдөлгөөнд саадгүй сайн чанарын материал оёдолтой будаг гардаггүй, бөөсрөхгүй, агшиж сунахгүй ханцуйтай байна.
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
4	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
5	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

Бүтээгдэхүүний нэр: Бяз даавуун малгай

Чанар, стандартын шарадлага	
1	Бяз даавуу сайн чанарын бөөсрөхгүй, агшиж сунахгүй байна..
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

Бүтээгдэхүүний нэр: Цамц, өмд

Чанар, стандартын шарадлага	
1	Бяз даавуу хөдөлгөөнд саадгүй сайн чанарын материал оёдолтой будаг гардаггүй, бөөсрөхгүй, агшиж сунахгүй ханцуйтай байна..
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

Бүтээгдэхүүний нэр: Цээживчтэй хормогч

Чанар, стандартын шарадлага	
1	Тос, ус нэвтэрдэггүй угааж цэвэрлэхэд хялбар байх
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

Бүтээгдэхүүний нэр: Хулдаасан хормогч

Чанар, стандартын шарадлага	
1	Үндсэн материал нь хулдаасан материалаар оёгдсон Тос, ус нэвтэрдэггүй угааж цэвэрлэхэд хялбар байх
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

Бүтээгдэхүүний нэр: Бяз даавуун нөмрөг

Чанар, стандартын шарадлага	
1	Бяз даавуу хөдөлгөөнд саадгүй сайн чанарын материал оёдолтой будаг гардаггүй, бөөсрөхгүй, агшиж сунахгүй байна..
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

Бүтээгдэхүүний нэр: Ажлын хувцас/ тусгай зориулалтын/

Чанар, стандартын шарадлага	
1	Хөвөн даавуун материалаар хийсэн байх. Хөдөлгөөнд саадгүй. Хөх өнгийн сайн чанарын оёдолтой, цацруулагчийн өргөн 5 см байна. Хувцасны дээд хэсгийн оруулга өнгө ногоон эмжээр цагаан байх. Энгэрт ил байрлах 2 хажуу талд 2 халаастай
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.
4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

Бүтээгдэхүүний нэр: Үйлчлэгчийн хувцас

Чанар, стандартын шарадлага	
1	Үндсэн материал нь хар хөх өнгөтэй байх будаг гардаггүй, хүний биед харшил өгөх нөлөөгүй байна.
2	Эрүүл ахуй халдвар судлалын байгууллагын тодорхойлолттой байна.
3	Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.

4	Тендерийн материалын хамт бүтээгдэхүүний дээжийг авчирна.
---	---

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл	1. Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч тал хариуцахгүй.
--	---

БАГЦ № 10 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүтээгдэхүүний нэр: Угаалгын үйлчилгээ

Техникийн тодорхойлолтын хураангуй. Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
Цагаан хэрэглэл	Угаалга ариутгал	Хүний биед харшлах бодис хэрэглэхгүй ариутгаж цэвэрлэж индүүдэх

- 1. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- 2. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 3. Бараа хүргэх газар:** [ҮБХИС-ийн байрлалд]
- 4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8

<i>[Дугаар бичих]</i>	<i>[Барааны товч тодорхойлолтыг бичих]</i>	<i>[нэгжийн тоо ширхэгийг бичих]</i>	<i>[Хэмжих нэгжийг бичих]</i>	<i>[Бараа хүргэх газрын нэр]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>
Багц 9	Бязь даавуун өмд, цамц, малгай	33	хос	Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хувцасны агуулах	2020 оны 06 сарын 15	2020 оны 07 сарын 15	
	Цээживчтэй хормогч	33	Ш				
	Хулдаасан хормогч	15	Ш				
	Бязь даавуун нөмрөг	5	Хос				
	Богино ханцуйтай бязь даавуун цамц өмд малгай /талхан цех/	3	Хос				
	Авто хуягт танк,инженерийн өмд, цамц	13	Хос				
	Брезинтэн бээлий	5	Хос				
	Үйлчлэгчийн хувцас	28	Хос				
Багц 10	Угаалгын зардал /орны хэрэглэл, бүтээлэг, майхан цув/	9320	ком	Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хувцасны агуулах	2020 оны 06 сарын 15	2020 оны 07 сарын 15	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Батлан хамгаалах яаманд

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Урьдчилгаа төлбөр:** Үгүй
- Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** Үгүй
- Барааг хүлээн авахад төлөх төлбөр:**
- НҮБ-аас санхүүждэг нөхөн төлбөрийн төлөлтөөс шалтгаалан нийлүүлсэн барааны гэрээний үнийн дүнг бараа ирснээс хойш 3 шатлалтайгаар буюу 1, 2 дугаар улиралд 30 хүртэл хувийг, 3 дугаар улиралд 30 хүртэл хувийг, 4 дүгээр улиралд 40 хүртэл хувиар захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,05]**
- Алдангийн нийт дүн: **[25 хувиас ихгүй байна]**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]